

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

2025.05.01

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Боловсролын ерөнхий газар, Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт арга зүйн үндэсний төв, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран Хэрлэн сумын 1, Хан-Уул сургуулийн хоол тэжээлийн орчинд үнэлгээ хийх ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 29-30 ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус үнэлгээнд сонгогдсон сургуулиудаас 10, Дорнод аймгийн Хүүхдийн зөвлөлөөс 10 нийт 20 суралцагч болон хоол зүйчийг хамрууллаа. Тус үнэлгээг батлагдсан удирдамжийн дагуу суралцагчдыг үнэлгээ хийх арга барил эзэмшүүлэх сургалтад хамруулж, үнэлгээг сонгогдсон сургуулиудад бэлтгэсэн судалгааны маягтын дагуу үнэлж, мэдээллийг цуглуулан ажиллалаа.

Үнэлгээний дата мэдээллийг сонгогдсон сургуулийн хоол зүйч нар нэгтгэн Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн мэргэжилтэнд хүргүүлж, үр дүн боловсруулагдаж байна.



Хоол үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан
ахлах арга зүйч Г.Сугар
Утас: 91106324
Мэйл хаяг: sugargerlee0819@gmail.com